# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
# 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
# ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Агуулга

1 Аудитын гэрчилгээ ... 2
2 Аудитын тайлан ... 4
2.1. Оршил ... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ... 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ... 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ... 7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ... 7
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ... 7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ... 8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ... 8
2.11. Шилэн дансны мэдээлэл ... 8
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ... 8
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ... 8
3 Менежментийн захидал ... 9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/243
танай ____________-ны № ____________-т

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ Д.БАТМӨНХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

УХА9122

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0225SAG6.Docx

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Батмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн ‘’Мэжик консалтинг аудит’’ ХХК-ийн багийн аудитын менежер С.Оюунцэцэг, аудиторын туслах Д.Наранбат нар хийж гүйцэтгэлээ.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үндсэн зорилго нь Байгалийн өвөрмөц тогтоц, экосистемийн онцлог төрх, байгалийн үзэгдэл, үйл явц болон нийслэл хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах, бүх нийтийн экологийн мэдлэгийг дээшлүүлж, байгалийн баялгийг зүй зохистой, тогтвортой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах чиглэлтэй.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд  буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Винница” програм хангамж ашигладаг байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1 хувиар сонгов.

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, материаллаг байдлын суурийг тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 366,369.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,662.6 мянган төгрөгөөр гэж урьдчилан тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулаагүй болно..

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 1 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшин Б201,аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшин В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаатай асуудлыг зөвлөмж өгөх Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаатай асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад дахин үнэлгээний өөрчлөлтөд залруулга хийгдсэн. Тухайлбал:
   Хандив тусламжаар авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд дутуу тусгасан буюу нийт хөрөнгийн дахин үнэлгээг хийгдээгүй байгааг илрүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгуулав.

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийж бүртгэлд бүрэн тусгуулсан болно.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 243,456.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл  243,456.2 мянган төгрөг байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар  100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 16,802,842.20 | 89.569.922.21 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 0.00 |
| 3121 | Төгрөг | 0.00 | 0.00 |
| 34 | Урьдчилгаа | 0.00 | 30,000,000,0 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 0.00 | 30,000,000,0 |
| 335 | Бусад авлага | 0.00 | 0.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 16,802,842.20 | 59,569,922,21 |
| 354 | Хангамжийн материал | 16,802,842.20 | 59,569,922,21 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 421,820.00 | 1,699,484,50 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,398.00 | 1,249,040,0 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 95,468.75 | 0.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 5,780,000.00 | 3,791,300,0 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,080,000.00 | 1,080,000,0 |
| 35460 | Хүнсний материал | 3,362,600.00 | 2,770,040,0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,013,555.45 | 48,980,057,15 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 347,391,970.33 | 1,068,785,746,87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 347,391,970.33 | 1,068,785,746,87 |
| 392 | Биет хөрөнгө | 347,391,970.33 | 1,026,015,746,87 |
| 39201 | Барилга, байгууламж | 131,129,004.80 | 768,974,802,82 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (51,265,463.76) | 12,292,380,02 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 266,603,138.97 | 266,603,138,97 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (100,274,025.13) | (133,058464,86) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 47,670,330,52 | 102,097,454,88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (18,608,301.77) | (31,673,580,06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,030,542,18 | 16,687,232,18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,380,946.06) | (14,832,841,42) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 28,447,260,24 | 63,098,186,72 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,625,569.66) | (24,172,562,38) |
| 393 | Биет бус хөрөнгө | | 42,770,000,0 |
| | | | |
| 39301 | Программ хангамж | 770,000.00 | 770,000,0 |
| 39302 | Хасагдуулга | (770,000.00) | |
| | Бусад биет бус хөрөнгө | | 42,000,000,0 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 338,194,812,53 | 1,158,355,669,08 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | (0.00) | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | (0.00) | |
| 413 | Өглөг | (0.00) | |
| 4131 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 338,194,812.53 | 1,158,355,669,08 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 338,194,812,53 | 1,158,355,669,08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал/згс | - | 159,944,500,0 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | - | 159,944,500,0 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 338,194,812.53 | 954,579,723,88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 338,194,812,53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 616,384,911,35 |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 43,831,445,20 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | 338,194,812.53 | 1,158,355,669,08 |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 578,471,965.09 | 1,044,351,062,39 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 410,426,665.09 | 720,773,262,39 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 371,970,665.09 | 720,773,262,39 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 371,970,665.09 | 720,773,262,39 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,481,521.00 | 59,858,300,0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 15,123,281,46 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 44,866,666.67 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 194,622,477.42 | 645,791,680,93 |
| 122 | Тусламжийн орлого | 38,456,000.00 | |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 38,456,000.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 168,045,300.00 | 323,577,800,0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 168,045,300.00 | 172,956,200,0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 168,045,300.00 | 172,956,200,0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 150,621,600,0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн | - | 17,000,000,0 |
| | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | | 46,425,000,0 |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | | 87,196,600,0 |
| | | | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 404,821,053,01 | 410,628,451,00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 404,821,053,01 | 410,628,451,00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 365,316,867,36 | 406,146,869,54 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 132,171,430.99 | 150,814,170,57 |
| 210101 | Цалин | 132,171,430.99 | 150,814,170,57 |
| 210105 | Гэрээтийн цалин | - | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,431,169.01 | 17,896,796,93 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 9,253,370.03 | 10,860,037,01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,051,493.85 | 1,504,315,48 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,314,367.30 | 2,222,958,83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 255,630.71 | 300,854,75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,556,307.12 | 3,008,630,86 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,453,854.35 | 25,443,600,0 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 13,715,100.00 | 11,183,100,0 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 9,547,754.35 | 13,815,000,0 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 2,191,000.00 | 445,500,0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,912,333.00 | 43,304,391,03 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 9,215,418.00 | 9,849,914,94 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,639,160.00 | 17,582,200,0 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 2,306,540.00 | 2,738,800 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,309,100.00 | 2,790,158,0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,442,115.00 | 10,343,318,09 |
| 2105 | Нормативд зардал | 16,315,738.15 | 2,441,998,30 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,315,738.15 | 2,441,998,30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,862,831,25 | 4,724,368,75 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 148,100,0 | 1,372,500,0 |
| 210604 | Урсгал засвар | 14,714,731,25 | 3,351,868,75 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,152,466,67 | 681,600,0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод томилолтын зардал | 2,152,466,67 | 681,600,0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 24,900,100,0 | 85,204,832,50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,601,500,0 | 83,835,332,50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | | 1,000,000,0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 257,400,0 | 320,000,0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 49,500,0 | 49,500,0 |
| 210807 | Газрын төлбөр | 3,991,700,0 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,116,943,94 | 75,635,111,46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,900,000,0 | |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 3,113,500,0 | 3113,500,0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 58,103,443,94 | 72,521,611,46 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,504,185,65 | 4,481,581,46 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,868,000,0 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 34,868,000,0 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,636,185,65 | 4,481,581,46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,636,185,65 | 4,481,581,46 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 173,650,912,08 | 633,722,611,39 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 371,908,52 | 17,337,700,04 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 371,908,52 | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | | 17,337,700,04 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | -371,908,52 | -17,337,700,04 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 173,279,003,56 | 616,684,911,35 |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| /Дансны код | Балансын зүйл | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 345,393,487.67 | 398,559,381,46 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 177,348,187.67 | 74,981,581,46 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 177,348,187.67 | 74,981,581,46 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 177,348,187.67 | 74,981,581,46 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,481,521.00 | 59,858,300,0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 15,123,281,46 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 44,866,666.67 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 168,045,300.00 | 323,577,800,0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 168,045,300.00 | 172,956,200,0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 168,045,300.00 | 172,956,200,0 |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 150,621,600,0 |
| 1311 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив | - | 46,425,000,0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | - | 17,000,000,0 |
| | Төсвийн байгууллагын үндсэн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | | 87,196,600,0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 345,177,487.67 | 398,559,381,46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 345,177,487.67 | 398,559,381,46 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 305,673,302.02 | 394,077,800,0 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 132,074,400.00 | 143,920,200,0 |
| 210101 | Үндсэн цалин | 101,890,900.00 | 110,906,100,0 |
| 210102 | Нэмэгдэл | 20,753,900.00 | 23,854,500,0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,429,600.00 | 9,429,600,0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | |
| 2102 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,528,200.00 | 17,270,300,0 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 9,245,200.00 | 11,825,300,0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,320,800.00 | 1,361,200,0 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,056,600.00 | 1,089,000,0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 264,100.00 | 272,200,0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 2,641,500.00 | 2,722,600,0 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 26,453,854.35 | 24,943,600,0 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 13,715,100.00 | 11,183,100,0 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 10,547,754.35 | 13,315,000,0 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 2,191,000.00 | 445,500,0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,479,939.00 | 29,872,700,0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,490,939.00 | 6,931,300,0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,373,360.00 | 15,093,500,0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,306,540.00 | 2,738,800,0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,309,100.00 | 5,109,100,0 |
| 2105 | Нормативд зардал | 346,500.00 | 346,500,0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 346,500.00 | 346,500,0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,894,542.00 | 6,473,100,0 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 8,319,542.00 | 2,898,100,0 |
| 210604 | Урсгал засвар | 2,575,000.00 | 3,575,000,0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,998,266.67 | 681,600,0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,998,266.67 | 681,600,0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,284,100,0 | 167,456,300,0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 12,985,500,0 | 166,086,800,0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 1,000,000,0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 257,400.00 | 320,000,0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 49,500.00 | 49,500,0 |
| 210807 | Газрын төлбөр | 3,991,700.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 82,613,500.00 | 3,113,500,0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,500,000.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,113,500.00 | 3,113,500,0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,504,185.65 | 4,481,581,46 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,868,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 34,868,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,636,185.65 | 4,481,581,46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,636,185.65 | 4,481,581,46 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 216,000,0 | |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 216,000,0 | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | |

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Балансын зүйл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | | | 177,421,908,45 | 177,421,908,45 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 177,421,908,45 | 177,421,908,45 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | - | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 160,772,904,07 | 160,772,904,07 |
| 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | | | 338,194,812,53 | 338,194,812,53- |
| 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 338,194,812,53 | 338,194,812,53- |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 43,831,445,20 | - | 43,831,445,20 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | - | - |
| Тайлант үеийн үр дүн | 159,944,500,0 | | 616,384,911,35 | 776,329,411,35 |
| 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 159,944,500,0 | 43,831,445,20 | 954,579,723,88 | 1,158,355,669,08 |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайланs

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 243.456.200.0 | 243.456.200.0 | | 100.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 243.456.200.0 | 243.456.200.0 | | 100.0 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 243.456.200.0 | 243.456.200.0 | | 100.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 143.920.200.0 | 143.920.200.0 | | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 110.906.100.0 | 110.906.100.0 | | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 23.584.500.0 | 23.584.500.0 | | 100.0 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 9.429.600.0 | 9.429.600.0 | | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17.270.300.0 | 17.270.300.0 | | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11.825.300.0 | 11.825.300.0 | | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1.361.200.0 | 1.361.200.0 | | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 1.089.000.0 | 1.089.000.0 | | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 272.200.0 | 272.200.0 | | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2.722.600.0 | 2.722.600.0 | | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24.943.600.0 | 24.943.600.0 | | 100.0 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 11.183.100.0 | 11.183.100.0 | | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 13.315.000.0 | 13.315.000.0 | | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 445.500.0 | 445.500.0 | | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20.094.400.0 | 20.094.400.0 | | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 5.931.300.0 | 5.931.300.0 | | 100.0 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 6.615.200.0 | 6.615.200.0 | | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 2.438.800.0 | 2.438.800.0 | | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 5.109.100.0 | 5.109.100.0 | | 100.0 |
| 2105 | Нормативд зардал | 346.500.0 | 346.500.0 | | 100.0 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 346.500.0 | 346.500.0 | | 100.0 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 2.723.100.0 | 2.723.100.0 | | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 148.100.0 | 148.100.0 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2.575.00.0 | 2.575.00.0 | | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 681.600.0 | 681.600.0 | | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 681.600.0 | 681.600.0 | | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 30.363.000.0 | 30.363.000.0 | | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28.993.500.0 | 28.993.500.0 | | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 320.000.0 | 320.000.0 | | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 49.500.0 | 49.500.0 | | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | | | | 100.0 |
| 2201 | Аудит баталгаажуулсан зэрэглэл тогтоох | 1,000,000,0 | 1,000,000,0 | | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,113,500,0 | 3,113,500,0 | | 100.0 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | | | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | | | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | | | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 243,456,200,0 | 243,456,200,0 | | 100.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 172,956,200,0 | 172,956,200,0 | | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 172,956,200,0 | 172,956,200,0 | | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 70,500,000,0 | 70,500,000,0 | | 100.0 |
| 120004 1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,500,000,0 | 70,500,000,0 | | 100.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 18.00 | 18.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 | - | 100.0 |

ТЭМДЭГЛЭЛ

....................................................................................................................................................................................................

....................................................................................................................................................................................................

ТЭМДЭГЛЭЛ

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................